



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 8/131

Мандалговь

Архи, согтууруулах ундаа худалдах,
түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай
зөвшөөрлийн эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 2.2.1, 5.3 дугаар зүйлийн 5.3.1 дэх заалт, 8.1 дүгээр зүйлийн 12.13 дахь хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хавсралтад дурдсан аж ахуйн нэгжийн архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрхийг 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс 2029 оны 02 дугаар сарын 17-ны өдөр хүртэл хугацаагаар олгосугай.

2. Холбогдох хууль, журмын дагуу аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ц.Ариунбаяр), Цагдаагийн газарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  С.МӨНХЧУЛУУН



4825100338

Аймгийн Засаг даргын 2025 оны 02
дугаар сарын 22-ны өдрийн 01/22/25
дугаар захирамжийн хавсралт

АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

№	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Аж ахуйн нэгжийн хаяг
1	Сайхан-Овоо	Элбэг онгийн хишиг	худалдаа	1-р баг Морин хөтөл 1-4 тоот
2	Сайнцагаан	Мөнхдэлгэрэх оюу	худалдаа	7-р баг, нарлаг, 46-р байр
3	Хулд	Хулд манлай	худалдаа	1-р баг шувуутай
4	Эрдэнэдалай	Анар ивээл	худалдаа	7-р баг
5	Говь-Угтаал	Их номгон хамтын хүч	худалдаа	1-р баг
6	Дэлгэрцогт	Төв тулга чандмань	жуулчны бааз	Төв, зуун мод, 6-р баг Баруун зуун мод
7	Сайхан-Овоо	Замбагын тал	зоогийн газар	1-р баг 2-2 тоот
8	Хулд	Төгрөгийн итгэлцэл	Худалдаа	1-р баг